



УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН
АЛБА



НЬЮ СЕМЕТРИ
ОРШООХ ҮЙЛЧИЛГЭЭ

ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

2021 оны 04 сарын 13-ны өдөр

№ 03.....

Улаанбаатар хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Далан давхар (Самбалхүндэв)-ийн оршуулгын газрыг хэсэгчлэн чөлөөлж, цэцэрлэгт хүрээлэн бүхий оршуулгын мэдээлэл, үйлчилгээний нэгдсэн төв барих төслийг хамтран хэрэгжүүлэхээр Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба (цаашид “Ажлын алба” гэх), “Нью семетри” ХХК /РД: 5065437 Хаяг: Сүхбаатар дүүргийн 1-р хороо автозамчдын гудамж/ (цаашид “Компани” гэх)-ийн хооронд энэхүү “Санамж бичиг”-ийг байгуулав.

ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлага” бүхий бодлогын баримт бичигт тусгасан Далан давхарын оршуулгын газарт Дурсгалын цэцэрлэгт хүрээлэн байгуулах төслийг үе шаттайгаар хэсэгчлэн хэрэгжүүлж, нийслэлийн хэмжээнд оршуулга, түүнтэй холбоотой тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг хангахад оршино.

ГУРАВ. ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3.1. Талууд хамтын ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.1.1. Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 15 дугаар тогтоолоор хаагдсан Самбалхүндэвийн оршуулгын газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны эзэмшилд авах.

3.1.2. Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлэх, нүүлгэн шилжүүлэх шарилын бодит тоо хэмжээ болон ар гэртэй холбоо тогтоох, мэдээллийн сан үүсгэх зэрэг газар чөлөөлөх ажлын бэлтгэл хангах.

3.1.3. Холбогдох хууль тогтоомж болон ёс заншил, уламжлалд нийцүүлэн нэгдүгээр ээлжинд 10 га талбайг чөлөөлөх (шарилыг ар гэрийн хүсэлтэд үндэслэн чандарлах эсхүл шилжүүлэх).

3.1.4. Чөлөөлсөн талбайд дараах чиглэлийн бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ:

- 2 га талбайд дурсгал, хүндэтгэлийн цэцэрлэгт хүрээлэн (оршуулгын зан үйл, уламжлалын таниулах хэсэг, чандарыг аравнайлан залах хана, суварга, ногоон байгууламж) байгуулах;
- 1 га талбайг чөлөөлж, олон улсын шаардлага, стандартад нийцсэн цогцос хадгалах байр барих зориулалтаар эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөх;
- 7 га талбайд Оршуулгын мэдээлэл, үйлчилгээний нэгдсэн төв барих;

3.2. Талууд холбогдох арга хэмжээг дор дурьдсан нөхцөл, журмаар хэрэгжүүлнэ:

3.2.1. Ажлын алба нь энэхүү санамж бичгийн 3.1.1, 3.1.2-д заасан арга хэмжээг зохион байгуулж, газар чөлөөлөх ажлыг эхлүүлэх нийгмийн болон эрх зүйн боломж, нөхцлийг хангана.

3.2.2. Компани нь өөрийн болон бусад боломжит хөрөнгийн эх үүсвэрээр 3.1.3-т заасан талбайг чөлөөлөх, 3.1.4-т заасан цэцэрлэгт хүрээлэн болон оршуулгын мэдээлэл, үйлчилгээний төв барих ажлыг гүйцэтгэнэ.

3.2.3. Талууд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг хамтран баталж, бүтээн байгуулалтын ажлын ерөнхий зураг, төслийг харилцан зөвшилцөнө.

ДӨРӨВ. БУСАД ЗҮЙЛ

4.1. Талууд "Санамж бичиг"-т тусгасан төслийг 2021-2024 онд хамтран хэрэгжүүлэх бөгөөд цэцэрлэгт хүрээлэн бүхий оршуулгын мэдээлэл, үйлчилгээний нэгдсэн төв барих төслийг хэрэгжүүлэх талуудын эрх, үүрэг, хариуцлага, чөлөөлөгдсөн газар болон төслийн хүрээнд бий болсон эд хөрөнгийн эрхийн эзэмшил, өмчлөлийн асуудлыг тусгайлан гэрээ байгуулах замаар зохицуулна.

4.2. Талууд улирал тутам "Санамж бичиг"-н хэрэгжилтийн явц, биелэлтийг дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг хэлэлцэн тохиролцоно.

4.2. "Санамж бичиг"-т талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.3. Энэхүү "Санамж бичиг"-ийг 2021 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр Монгол хэл дээр хоёр хувь үйлдсэн бөгөөд бичвэрүүд нэгэн адил хүчинтэй байна.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ
МЕНЕЖЕР БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



Т.ГАНТӨМӨР

"НЬЮ СЕМЕТРИ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



УЛААНБААТАР ХОТ
НЬЮ СЕМЕТРИ
Х.МОНХЗАЯ
1118269293 5065437
AMT01605